

НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (мян, төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	1	2	3	4	5	6	7
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ							
Зорилт 1. МУЗГҮАХ 3.3.6.10.Үндэсний өв уламжлал, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, зэрэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.							
1.1.1	Үндэсний өв уламжлалыг шингээсэн уран бүтээл, бүтээгчдийг дэмжиж иргэд, олон нийтэд чиглэсэн сурталчлан таниулах, арга хэмжээг байгууллагын түвшинд зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	6	Үндэсний өв уламжлалт тоглолт, уран бүтээлчдийг дэмжих, иргэд олон нийтэд суртчилан таниулах үүднээс жилийн эцсийн байдлаар дараах 6 арга хэмжээг зохион байгуулж ажилласан 1.2025.02.08-нд Казахстан улсын дуучин Роза Рымбаевагийн тоглолт 2.2025.02.23-нд МУ-ын консерватор “Морин хуурын чуулга” тоглолт 3. 2025.03.15-нд АДБ-ын Хан Хэнтий Чуулга “Үлэмж төгөлдөр” тоглолт 4.2025.03.22-нд “Наурызын баяр”-ын арга хэмжээг хамтран зохион байгуулсан. 5.2025.03.25-нд МУХБ,ТХШ,АЖ Н.Жанцанноровын “Хүслийн төвөргөөн” тоглолт	100

						6.2025.07.10-нд "Алтан соёмбот Монгол" төрийн хүндэтгэлийн наадмын концертийг тус тус хамтран зохион байгуулсан.	
Зорилт-2. ЗДҮАХ 2.4 Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.							
1.2.1	Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, олон нийтийн тав тухтай үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээнд тавих стандартыг хангаж, үзэгчдийн үзвэр үзэх соёлыг төлөвшүүлж, үзвэрийн танхимд соёлтой үйлчлүүлэх дадлыг хэвшүүлнэ.	-	Их танхимаар үйлчлүүлсэн үзэгчдийн тоо	Аудио бичлэгийг 60,000 гаруй үзэгчдэд хүргэсэн байна.	Аудио бичлэгийг 80,000 гаруй үзэгчдэд хүргэнэ	Үзэгчдийн үзвэр үзэх соёлыг нэмэгдүүлж, үзвэрийн танхимд үйлчлүүлэх, үзвэрийн танхимд ус ундаа, хүнсний бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглосон тухай "Аудио бичлэг"-ийг тоглолт арга хэмжээ эхлэхийн өмнө завсарлагаагаар сонсгож анхааруулж ажиллаж байна. "Аудио бичлэг"-ийг 125,000 гаруй үзэгчдэд хүргэсэн байна.	100
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 1. "Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах" зорилтын хүрээнд							
2.1.1	Байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.	-	Сургалтад хамрагдсан хүний тоо	3	5	1. "Жендерийн тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо" уриан дор зохион байгуулагдсан сургалт 2. "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дадлага, сургуулилтад бүх албан хаагч оролцсон 3. "Худалдах, худалдан авах үйл ажиллагааны АЗ"-н сургалтад 7 албан хаагч шалгалтад тэнцсэн. 4. "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах дүгнэх" сургалт	100

						5. “Шинэчлэн батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын танилцуулга” сургалт 6. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтуудад хамрагдсан байна. 7. Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалт 1 хүн хамрагдаж тэнцсэн.	
2.1.2	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	33,905.8	Тэтгэмж авсан ажилтны тоо	2024 онд ажил олгогчоос 16,525,000 төгрөгийн тэтгэмж олгосон	2025 онд ажил олгогчоос 30,905,800.0 төгрөгийн тэтгэмж олгосон	Байгууллагын Маркетинг үйлчилгээний хэлтсийн үйлчлэгч Х.Ариунтуяад тэтгэвэрт гарахад 15,905,800 төгрөг, Эх үрсийн баярын арга хэмжээнд нийт ажилчдын 18 хүртэлх насны хүүхдүүдэд гарын бэлэгт зориулж, 6,500,000 төгрөг, байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд 18,650,000 төгрөг, буцалтгүй тусламжид 9,500,000 төгрөг нийт 50,555,800 төгрөг зарцуулсан байна.	100
2.1.3	Байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	100%	Байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Улсын төв 1 дүгээр эмнэлгийн эрүүл мэндийг дэмжих төвд 253.000 төгрөгийн үнэ бүхий урьдчилан сэргийлэх үзлэгт байгууллагын нийт албан хаагчдыг 2025.12.23-2025.12.27 хооронд хамрагдахаар гэрээ хийгдсэн.	95

2.1.4	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	100%	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг байгууллагын хүрээнд хэрэгжүүлж, 2025 оны байдлаар өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан авлигын эсрэг зарласан аяны хүрээнд байгууллагын албан хаагчдын хурал дээр байгууллагын хууль, эрх зүйн мэргэжилтэн 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн “Авлигаас ангид хүнд сурталгүй ажиллахыг” уриалсан видео контент, постерыг байгууллагын цахим хаягт байршуулсан.	100
2.1.5	“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	100%	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ёс зүйг дүрмийг баримтлан ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын албан хаагчдын дунд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй байна.	98

2.1.6	Жендэрт суурилсан үндэсний хэмжээний аяныг зохион байгуулах, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран видео контент хэлбэрээр олон нийтэд түгээнэ.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	80%	2025 оны 03 сарын 24-нд Жендэрийн үндэсний хорооны сургалт мөн "Жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт" сэдэвтэй сургалтуудад жендэр хариуцсан ажилтан С.Гантөмөр хамрагдлаа. - "Харилцан хүндэтгэв", "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье" аянуудад нэгдэж, албан хаагчдад 2 удаагийн сургалт семнар зохион байгуулсан. Байгууллагын цахим хуудсаар нийт 4 рийл мөн Жендэрийн үндэсний хорооноос гаргасан 5 постерыг мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд дамжуулсан.	100
2.1.7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	100%	Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангаж, байгууллагын 4 байршилд галын сарай, 30л галын хор 8 байршилд, 3 ширхэг жижиг хорыг цэнэглүүлж, 18 ширхэг галын хорыг акталсан. Соёлын төв өргөөний "А", "Г" байрны 22 байршилд аваарын гарцны схем зураг хийлгэсэн. Инженер техникийн хэлтсийн 14 албан хаагчдад ажлын хувцас, гутал, шаардлагатай байсан (багажны хайрцаг) багажаар хангасан. Мөн архивын өрөөнд хяналтын камер байршуулсан. Өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгч ажиллаж байна.	100

2.1.8	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхтэй хамрагдана.	-	Тарьсан модны тоо	50	55	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн соёлын төв өргөөний хамт олон 2022 онд ХУД 14-р хороо, айдсын даваанд 100 орчим модыг тарьсан. 2025 оны 05 сарын 11-нд болон 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрүүдэд хамт олноороо очиж ойр орчмыг цэвэрлэж, усалгаа, хөрсийг сийрэгжүүлэх ажлыг хийж ажиллаа.	100
2.1.9	Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ.	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	80%	“Нийслэлийн Соёлын төв өргөө” нь төсөвт байгууллагын хэлбэрээс НИТХ-ын 25/26 дугаар тогтоолоор хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдөж Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон өөрчлөгдөж, дүрмийг шинэчлэн баталсан.	100
2.1.10	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	-	100%	Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Засаглалын шинэчлэл, цахим хөгжил, төрийн үйлчилгээг боловсронгуй болгох асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр хянуулаад сайжруулалт хийгдэж байна.	90
2.1.11	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын Монгол бичгийн үр чадварыг нэмэгдүүлэх	-	Үйл ажиллагаа ны хэрэгжилт хувь	80	90	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, “Урлан бүтээх төв”-ийн багш нартай хамтран албан хаагчдад зориулсан Монгол бичгийн сургалт явуулж үндэсний бичгээ эзэмших, өв уламжлалаа сэргээх, уран бичлэгийн өдөрлөгийг 2025 оны 05 сарын 08-ны өдөр зохион	100

						байгууллаа. Мөн байгууллагын албан хаагч Д.Энхмаа нь Монгол бичгийн сургалтыг захиргааны албан хаагчдад анхан, дунд шатны мэдлэгийг олгох сургалт болон мэргэжил арга зүйн зөвлөгөөг 2024 оноос эхлэн тогтмол өгч байна.	
Зорилт 2. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангана.							
2.2.1	Байгууллагын мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллана.	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд 171 мэдээллийг байршуулж ажилласан.	Шилэн дансны тухай хуулийн дагуу 2025 онд 171 мэдээллийг байршуулж ажиллана.	Төсөв, санхүүгийн ил тод байдлын хангаж, төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж, шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээ мэдээллийг тухай бүр тайлагнан мэдээлж ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын "Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу цаг үеийн мэдээллийн самбарт өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж, шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын www.stu.ub.gov.mn хаягт 84, цахим хаягт 127 мэдээлэл оруулж тогтмол ажиллуулж байна.	100

2.2.2	Байгууллагын www.stu.ub.gov.mn домайн хаягтай цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчилж, баяжуулах, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж, ил тод байдлын тухай хуулийг баримталж хэрэглэгчдийг мэдээллээр хангана.	-	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь	80%	90%	Нийслэлийн Соёлын Төв Өргөө нь 2025 оны жилийн эцсийн байдлаар вэб сайт, пэйж хуудас, youtube сувагт тоглолтын болон цаг үеийн мэдээллийг тухай бүрд нь видео, фото мэдээг www.stu.ub.gov.mn хаягт 84, пэйж хуудсанд нийт 127 мэдээ оруулснаас 30 видео бичлэг оруулсан байна.	98
2.2.3	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90%	Байгууллагын үйл ажиллагааны статистик, мэдээллийг үйл ажиллагааны чиглэл, үйлчлүүлэгчийн, албан хаагчдын мэдээллүүдийг нэгтгэн Нийслэлийн Соёл урлагийн газарт улирал тутам болон жилийн эцсийн байдлаар тогтмол хүргүүлж ажиллаж байна.	96
2.2.4	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж. Олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	-	90%	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулах байгууллагын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээг хийж байна.	80
2.2.5	Түрээслэгчдийн сэтгэл ханамжийн байдалд судалгаа хийж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн хэрэгжилтийг хангасан байна.	80%	90%	Түрээслэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг Соёлын төв өргөөний "Г" байрны 38 түрээслэгч төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудын дунд хийж, судалгааны үр дүнд суурилсан өмч ашиглалтыг сайжруулж, өдөр тутмын засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Мөн өмнөх жилүүдийн судалгаануудад үндэслэж "Г"	95

						байрны их засварын ажлыг хийж гүйцэтгээд байна. MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалтыг эрх бүхий байгууллагаар хийлгэхээр бэлтгэл ажил хангаж, 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжилтийг хангаж ажиллана.	
Зорилт 3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.							
2.3.1	Гадаад орнуудын болон найрамдалт хотуудын соёлын өдрүүдийн соёл урлагийн арга хэмжээг хамтран зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо			Бүгд Найрамдах Буриад улстай хамтран дайны ялалтын 80 жилийн ойд зориулсан "Ялалтын баяр"-ын хүндэтгэлийн концертыг зохион байгуулсан.	100
Зорилт 4.Төсөв, санхүүгийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулна.							
2.4.1	Барилга байгууламжийн дулаан, цахилгаан, ус хангамж, хог тээвэр болон лифтний засвар үйлчилгээний холбогдох аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулж найдвартай ажиллагааг хангаж ажиллана.	727,862.3	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100%	100%	Барилга байгууламжийн дулаан, цахилгаан, цэвэр бохир ус, хог тээвэр, лифтний засвар үйлчилгээг хангах талаар аж ахуй нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангаж 480,801.6 мянган төгрөгийн төлбөрийг төлж ажиллаа.	95
2.4.2	Байгууллагад шаардлагатай багаж техник хэрэгсэл, Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл урсгал засварын материал	593,503.4	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100%	100%	2025 оны жилийн эцсийн байдлаар шаардлагатай багаж техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын	98

	худалдан авч засвар үйлчилгээг хийх.					хэрэгсэл, урсгал засварын материал худалдан авч засвар урсгал засварын зардалд 509,871,4 мянган төгрөгийг зарцуулаад байна.	
2.4.3	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, хуулийн хугацаанд мэдээ тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах.	4,194,756.8	Үйл ажиллагаа нь хэрэгжилт хувь	100%	100%	Батлагдсан төсөвт багтаан ажилтан албан хаагчдад 2,923,486.6 мянган төгрөгийн цалин урамшууллыг зохих журмын дагуу хугацаанд нь олгож ажиллаж байна. Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангахад шаардлагатай бичиг хэрэг шуудан холбоо, өөрийн болон түрээслэгч байгууллагуудын хог ачуулах, ариутгал хийлгэх, цэвэрлэгээний материалыг батлагдсан төсвийн хүрээнд авч төлөвлөгөөний дагуу зарцуулан ажиллалаа.	100
Зорилт 5. Нийслэлийн иргэдэд соёл урлагаар үйлчлэх, түрээсийн гэрээ байгуулах, биелэлтийг хангуулах, орлогыг гэрээний хугацаанд бүрдүүлэх ажлыг зохион байгуулна							
2.5.1	Нийслэлийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/33 дугаар захирамжийн биелэлтийг хангуулна.		Үйл ажиллагаа нь хэрэгжилтийн хувь	100%	100%	1.2025.03.21-нд "Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ-ын арга хэмжээ 2.2025.04.27-нд Нийслэлийн намын хорооны 100 жилийн ойн арга хэмжээ 3. 2025.05.03-нд НЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн алба "Хэвлэлийн эрх чөлөө"-ны өдрийн арга хэмжээ 4. 2025.05.04-05-нд Монгол болон Буриад улсын уран бүтээлчдийн хамтарсан хүндэтгэлийн тоглолт	

					5. 2025.05.24-д НЗДТГ, ННБХ, НБТСГ-аас хамтран зохион байгуулж буй "Улаанбаатар марафон 2025" 6.2025.06.01-нд НЗДТГ, НБИХГ, НХГБХГ-аас хамтран зохион байгуулж буй "ESPORT" тэмцээний арга хэмжээ 7. 2025.06.12-14-нд JCI Asia-Pacific Conferense 2025 арга хэмжээний хүрээнд "Гайжин" жүжгийн тоглолт 8. 2025.09.04-нд Монгол улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдах "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын ахлах офицеруудын чуулган" болон "Чөлөөлөх дайны ялалтын 80 жил"-ийн ойг угтсан арга хэмжээ 9. 2025.07.17-19-нд Archilles ХБИ-ийн "Улаанбаатар марафон-2025" 10. 2025.10.08-нд ЗХЖШ-ын "Энхийг дэмжих цэргийн хамтын ажиллагаа"-ны арга хэмжээ 11.2025.11.24,25-нд Нийслэлийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан "Өсвөрийн Хийлчдийн нээлттэй 6-р уралдаан" 12. 2025.12.03-нд НЗДТГ-аас ХБИ-ийн эрхийг хамгаалах өдрөөр	100
--	--	--	--	--	---	-----

						Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 1200 ХБИ болон тэдний асран хамгаалагч нарт зориулж “Ээж минь” тоглолтыг амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт 12 удаагийн арга хэмжээнд 83 цагийн бэлтгэл сургуулилт тайз засал хийгдэж, 87 цагийн 261,000,000 төгрөгийн арга хэмжээг үнэ төлбөргүй хамтран зохион байгуулж ажиллаа.	
2.5.2	Нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг аж ахуйн нэгж, иргэдэд зориулалтын дагуу түрээслүүлэх, түрээсийн орлогыг гэрээний хугацаанд бүрдүүлнэ.	-	Түрээсийн орлогоор	1,197,399.0	1,218,000.0	2025 онд 35 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай түрээсийн гэрээ байгуулан ажиллаж 2025 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2,136,127.8 мянган төгрөгийн түрээсийн орлогыг бүрдүүлж, УБХХК-д 30,056.4 мянган төгрөгийг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэн ажиллалаа. НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, төсвийн сахилгыг чанд сахиж ажиллаж байна.	100
2.5.3	Их танхимыг Соёл урлагийн тоглолт, арга хэмжээнд төлбөртэй ашиглуулна.	-	Түрээсийн орлогоор	652,000.0	1,100,000.0	Жилийн эцсийн байдлаар их танхимыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад соёл урлагийн тоглолт, арга хэмжээнд түрээсэлсэн орлогоор 878,406.8 мянган төгрөгийг бүрдүүлж үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж ажиллаж байна	95
2.5.4	Үндэсний их баяр наадмын хүндэтгэлийн 104 жилийн ойн тоглолтыг хамтран зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан арга хэмжээний тоо	1	1	Үндэсний их баяр наадмын хүндэтгэлийн 104 жилийн ойн тоглолтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ноос эхлэн нэгдсэн бэлтгэж хийж, 2025 оны 07 дугаар сарын 10-ны	100

						өдөр “Алтан соёмбот Монгол” төрийн хүдэтгэлийн тоглолтыг зохион байгуулагдсан.	
2.5.5	Нийслэл хот үүсэж байгуулагдсаны түүхт 386 жилийн ойн хүндэтгэлийн концертыг хамтран зохион байгуулна.	-	Зохион байгуулагдсан үзвэр арга хэмжээний тоо	1	1	Энэ жил Нийслэл хот үүсэж байгуулагдсаны түүхт 386 ойн тоглолтыг 06 дугаар сард Чингисийн талбай дээр зохион байгуулагдсан учраас IV улиралд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн арга хэмжээ зохион байгуулагдаагүй.	80
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА, ХЭМЖЭЭ							
Зорилт 1. Нийслэлийн өмч ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангаж үйлчилгээ явуулах таатай орчныг бий болгоно							
3.1.1	Байгууллагын “А”, “Г” байрны дээврийн иж бүрэн засварыг хийж гүйцэтгэнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	90	Соёлын төв өргөө”-ний хөрсний ус зайлуулах, барилгын их засварын ажил НХААГ/20250101640 дугаартай тендер шалгаруулалт явуулж “Люксдаймонд”ХХК 645,088,802 төгрөгөөр “А” блокийн дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэхээр Нийслэлийн засаг даргын тамгын газартай гэрээ хийн дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүлээж авах үйл ажиллагааг зохион байгуулагдлаа.	100
3.1.2	Байгууллагын “Г” хэсгийн лифтын хүлээлгийн хэсгийн 1-12 давхрын шаардлагатай байгаа 60 орчим радиаторыг сольж, дулаан алдагдалтыг багасгаж, үйлчлүүлэгчдийн таатай орчныг бүрдүүлж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	40	60	Байгууллагын “Г” хэсгийн лифтний хүлээлгийн хэсгийн 1-12 давхрын шаардлагатай байгаа 63 орчим радиаторыг сольж, дулаан алдагдалтыг багасгаж, үйлчлүүлэгчдийн таатай орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллаа.	100

3.1.3	Байгууллагын "Г" байрны 1-12 давхарын нийт 22 ариун цэврийн өрөөг тохижуулан шинэчилж, 44 суултуур, 24 модон цонхыг вакум цонхоор сольж, дулаан алдагдлыг бууруулан түрээслэгчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж ажиллана.	-	Тохижуулсан өрөөний тоо	-	22	Соёлын төв өргөө"-ний хөрсний ус зайлуулах, барилгын их засварын ажил НХААГ/20250101640 дугаартай тендер шалгаруулалт явуулж "Ди Би Ти Би" ХХК нь 678,000,000 төгрөгөөр "Г" байрны 1 давхрын гадна тал, 1 давхрын лобби хэсэг, 1-12 давхрын лифтний хүлээлгийн хэсгийг засварлах их засварын ажлыг хийж гүйцэтгэхээр Нийслэлийн засаг даргын тамгын газартай гэрээ байгуулан, их засварын ажлыг хийж гүйцэтгэж дууссан байна.	100
3.1.4	Байгууллагын "Г" байрны гадна болон дотор талд иж бүрэн камержуулах ажлыг хийж гүйцэтгэж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	90	Байгууллагын "Г" байрны гадна талд 360 градус эргэдэг 2 камерыг нэмж байрлуулсан. Мөн "Г" байрны 1-12 давхрыг иж бүрэн камержуулах ажлыг хийж гүйцэтгэж дууссан байна.	98
3.1.5	Байгууллагын "Г" байрны гадна талын фасадыг эмульсдэж, байгууллагын гадна өнгө үзэмжийг сайжруулжна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	90	Байгууллагын барилгын их засварын ажлыг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалт явуулж "Ди Би Ти Би" ХХК нь 678,000,000 төгрөгийн гэрээ байгуулсан. Үүнд "Г" байрны гадна талын фасадыг эмульсдэж, гадна хаягжилтыг шинэчилэх, гадна талын чулуун фасад болон шатны плитануудыг иж бүрнээр сольж, байгууллагын гадаад өнгө үзэмж, өмч ашиглалтыг сайжруулан ажиллаа.	100

3.1.6	Байгууллагын "Г" байрны ачааны болон хүн тээврийн 4 ш лифтийг шинээр солих	-	Лифтний тоо	-	4	Соёлын төв өргөө"-ний Тоног төхөөрөмж нийлүүлэх НХААГ/20250102641 дугаартай тендер шалгаруулалт явуулж "Лифт инсфекшн" ХХК шалгарч "Г" байрны ачааны болон хүн тээврийн 4ш лифтийг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэж өгөх бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэж байна.	95
-------	--	---	-------------	---	---	---	----

2025 онд нийт 3 чиглэлийн хүрээнд 8 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ төлөвлөсөн.

Үүнээс 31 арга хэмжээ биелэгдсэн байна.

Дундаж хувь: 97%

Төлөвлөгөөний биелэлттэй танилцсан:
"Нийслэлийн соёлын төв өргөө" ОНӨӨАТҮГ Захирал



ЛАРИУНТУЯА

Төлөвлөгөө тайлагнасан:
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Ч.ХИШИГСҮРЭН